



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар A/153

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/435 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг сумын Эрүүл мэндийн төвд зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: П.Аюушжав (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Орбиш (Хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан)

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг удирдамжийн дагуу зохион байгуулж үзлэгийн тайланг 2022 оны 10 дугаар сарын 03-ны дотор Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

